



**Оюу Толгой ХХК**

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны  
удирдлагын тогтолцооны журам

Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E7-PRC-0001-M	Хувилбар: 1.0

### 1 ЗОРИЛГО

Энэ баримт бичгийн зорилго нь холбогдох хууль дүрмээр хүлээн үүрэг, Рио Тинтогийн стандартууд, Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОННБҮ) шаардлагууд зэрэг төслийн дагаж мөрддөг бусад стандартуудад нийцүүлэн Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагааны журмыг тодорхойлоход оршино.

Энэ журамд хог хаягдал, бохирдолоос татгалзах, түүнийг хянахад тавигдах үндсэн шаардлагууд, Хог хаягдлын удирдлагын төвийг үр ашигтай ашиглах, үйлчилгээ хийх, завсар үйлчилгээ хийхтэй холбоотой гол үүрэг хариуцлагуудыг тодорхойлж өгсөн болно.

### 2 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журмыг нь Оюу Толгой ХХК-ийн болон түүний өмнөөс үйл ажиллагаа явуулж буй бүх ажлын талбаруудад мөрдөнө.

### 3 АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Албан тушаал	Үүрэг хариуцлага
<b>ЭМААБО-ы Ерөнхий менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Энэ журмыг хэрэгжүүлэхэд удирдлагын дэмжлэг үзүүлэх, шаардлагатай нөөцөөр хангах</li> <li>• Энэ журмыг баталж, Оюу Толгойн нийт үндсэн ба гэрээт ажилтнуудад хүргэх</li> </ul>
<b>Байгаль орчны менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гарсан хог хаягдалд хяналт тавих байгаль орчны мэргэжилтнүүдийг ажиллуулж, хог хаягдлын удирдлагын чиглэлээр үндсэн ба гэрээт ажилтнуудад зөвлөгөө өгөх</li> </ul>
<b>Хэлтсүүдийн менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хариуцсан хэлтсийнхээ хэмжээнд гарсан хог хаягдлын талаарх мэдээллийг Хог хаягдал, химийн бодисын зохицуулагчид сар бүр тайлагнах</li> </ul>
<b>Ахлах мэргэжилтэн/Ахлах ажилтнууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Тэмдэглэгээтэй, нэвтрэх боломжтой, хог хаях зориулалтын газруудад хогийн сав байрлуулах</li> <li>• Энэ журмын дагуу хог хаягдлыг ангилах, зайлуулах</li> <li>• Хог цуглуулах цэгт тогтмол үзлэг шалгалт хийх</li> <li>• Хог хаягдал зайлуулах байршлын талаар Хог хаягдал, химийн бодисын зохицуулагчтай зөвлөлдөх</li> <li>• Эдийн засгийн хувьд боломжийн, бодитоор хэрэгжүүлэх боломжтой бол материалыг Хог хаягдлын удирдлагын төвд устгалд оруулахын оронд хариуцсан ажлын талбартаа үр ашигтай бүтээгдэхүүн худалдаж авах, сав баглааг багасгах, дахин ашиглалт, дахин боловсруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарах</li> </ul>
<b>Хог хаягдал гаргасан хүн</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Аюултай бодисыг устгах, тээвэрлэх, бодистой харьцах, хадгалах устгах талаар энэ журамд орсон процессыг дагаж мөрдөх</li> <li>• Хууль журмын дагуу авах шаардлагатай зөвшөөрөл авахад хангалттай хугацаа төлөвлөх</li> </ul>
<b>Байгаль орчны ажилтан-зөвшөөрөл өгөх, батлах</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Аюултай бодис ашиглах буюу устгах зөвшөөрөл хүссэн хүсэлтэд хариу өгөх</li> <li>• Захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, шаардлагатай хууль зүйн зөвшөөрөл авах</li> </ul>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E7-PRC-0001-M	Хувилбар: 1.0

<b>Хог хаягдал, химийн бодисын зохицуулагч</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Аюултай хог хаягдлыг устгах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах</li> <li>• Хог хаягдлын бүртгэл хөтлөх</li> <li>• Энэ журам болон холбогдох бусад удирдамжуудыг хэрэгжүүлэхэд үндсэн ба гэрээт ажилтнуудад техникийн туслалцаа үзүүлэх</li> <li>• Ажлын талбарт ээлжит хяналт, шалгалт, үзлэг хийх</li> <li>• Шаардлагатай тохиолдолд аюултай хог хаягдлыг устгалд оруулах хүсэлтийг батлах</li> <li>• Хог хаягдлын хэмжээ, бодит гүйцэтгэлийг холбогдох зорилго, зорилттой харьцуулан судлах</li> <li>• Мэдээлэл солилцох уулзалт, сургалт, мэдээлэл өгөх материалаар (постер зэрэг) дамжуулан Хог хаягдал ангилах журамд орсон өөрчлөлтийн талаар үндсэн ба гэрээт ажилтнуудад мэдээлэх</li> </ul>
<b>Ландфилийн ажиллагаанд оролцох ажилтнууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Эдгээр журам, холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх</li> <li>• Бүх төрлийн аюултай хог хаягдлыг Хог хаягдлын удирдлагын төвд хадгалж, асгарах, осол зөрчил, аюул эрсдэл гарах магадлалыг бууруулах</li> </ul>
<b>Нийт үндсэн ба гэрээт ажилтнууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Бүх хог хаягдлыг зориулалтын хогийн сав, хадгалах цэгт хадгалах</li> <li>• Ахлах мэргэжилтэн, Ахлах ажилтнуудаас шаардсаны дагуу хог хаягдлын удирдлагын сургалтад хамрагдах</li> </ul>
<b>Сургалтын менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Танилцуулах сургалт, бусад сургалтын хөтөлбөрүүдээр дамжуулан үндсэн ба гэрээт ажилтнуудад хог хаягдал ангилах журамтай холбоотой сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох</li> </ul>

### 4 ЖУРАМ

#### 4.1 Хог хаягдал устгах

##### 4.1.1 Ерөнхий

Хог хаягдлын удирдлагын төвд дараах ерөнхий шаардлага тавигдана:

- a) Дахин боловсруулах боломжгүй аюултай хог хаягдлыг Хог хаягдал цуглуулах, зөөвөрлөх ерөнхий журамд заасан зааврын дагуу хуулиар зөвшөөрөгдсөн тохирох арга технологийн дагуу устгалд оруулна;
- b) Бүх төрлийн шингэн аюултай болон аюултай бус хог хаягдлыг түр хадгалах цэгт цуглуулж, удирдлагын арга хэмжээний тохирох шатлалын дагуу хог хаягдлын удирдлагын төвд устгалд оруулна;
- c) Дахин ашиглах, дахин боловсруулах боломжгүй шингэн бус хог хаягдлыг шатаана эсвэл буюу аюултай биш гэж үнэлбэл ландфил буюу булах цэг рүү илгээнэ.

##### 4.1.2 Ландфилийн аргаар булах

Ландфилдэх буюу хөрсөөр дарж булахад дараах үндсэн шаардлагыг тавина:

- a) Хог хаягдлын түр байгууламж дахь хог хаягдлыг Хог хаягдлын удирдлагын төв ашиглалтад ормогц шилжүүлэн зөөвөрлөнө. Түр байгууламжийг хаахын өмнө шаардлагатай бол ариутгал хийнэ. Энэ үйл ажиллагааг Ландфилийн түр цэгийг хаах журмын дагуу явуулна;
- b) Операторуудыг аюултай хог хаягдлыг ялгаж таних сургалтад хамруулна;
- c) Байгууламжид хортой хог хаягдал устгалд оруулахаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах ажлыг хэрэгжүүлнэ:

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е7-PRC-0001-М	Хувилбар: 1.0

- Байгууламжийн удирдах ажилтнуудад зориулсан аюултай хог хаягдлыг ялгаж таних тухай сургалт;
- Үзлэг шалгалт (үзлэг шалгалтын бүртгэл багтана);
- d) завсарын болон хамгийн сүүлчийн хучилт хийхдээ хөрсөөр хучих хамгийн тохиромжтой материалыг ашиглана. (хамгийн багадаа 30 см-ийн зузаантай);
- e) Операторууд хог хаягдлын жагсаалт, үзлэг шалгалт, сургалтын бүртгэлийг хөтөлнө.

### 4.1.3 Шатааж устгах:

Оу Толгойд хог хаягдлыг шатааж устгахад дараах үндсэн шаардлага тавина:

- Оюу Толгойд хог хаягдлыг шатааж устгахдаа 2000 оны 12 сарын 4-ний өдрийн 2000/76/ЕС тоот ЕХ-ны шийдвэрт дурдсан шаардлагуудыг мөрдлөг болгоно;
- Дараах материалыг шатааж устгахыг зөвшөөрнө:
  - Тостой даавуу, хаягдал тос, тослох материал;
  - Тос шүүгч;
  - Эмнэлгийн хог хаягдал: шатааж устгах ажиллагаанд эмнэлгийн ажилтныг байлцуулах шаардлагатай;
  - Аюултай хог хаягдал: шатамхай шинж чанартай, шатааж устгахыг зөвшөөрсөн аюултай хог хаягдал;
- Шатааж устгахыг хориглосон хог хаягдалд хлорын найрлагатай уусмалууд орно. (1,100°C-с бага температурт диоксин ялгаруулах эрсдэлтэй бөгөөд 2 секундээс илүү байж болохгүй учир).

## 4.2 Ландфилийн үйл ажиллагаа

### 4.2.1 Тухайн өдөр ашиглах нүхийг бэлтгэх /дүүргэх

Тухайн өдөр ашиглах ландфилийн нүх бэлтгэх ажил нь дараах 5 үндсэн алхамаас бүрдэнэ:

1. Үзлэг шалгалт хийх – хог хаягдлыг овоолсны дараа илрүүлэгч багажаар ачааг шалгаж, ямар нэгэн аюултай болон доторлогоог гэмтээх ямар нэгэн эл зүйл байгаа эсэхийг үзэж шалгана. Хэрвээ дээрх зүйлс илэрвэл хогийг тухайн нүхнээс холдуулах ба ландфилийн Ахлах ажилтанд мэдэгдэж дараагийн арга хэмжээг авхуулна.
2. Хог хаягдлыг түрэх – бульдозер нүхэн дотор урагш хойш аль болох их явж, хатуу/үзүүртэй ирмэгүүдийг багасгаж, жигдэлж өгнө (буцаж эргэж явснаас урагш хойш явах нь илүү үр дүнтэй бөгөөд энэ нь HDPE доторлогоонд бага даралт өгдөг). Бульдозер нь шанагаараа ачааг утган авч нүх рүү хийнэ. Ерөнхийдөө нэг ачааны машин энгийн хогийг 3-4 удаагийн явалтаар нүхэнд хийдэг. Хүнд, овор ихтэй хог хаягдлын хувьд нэмж 1-2 удаа явалт хийх хэрэгтэй болдог.
3. Хог хаягдлыг тараах – бульдозер хогийг нүх рүү хийх үед шанага нь дээш өргөгдсөн байх ёстой бөгөөд ингэснээр хог хаягдлыг нүх рүү хийж, хог шанаганы доогуур гарч, жигд тараана. Хог хаягдлыг түрэхдээ 3:1 налуугийн харьцааг баримтлах хэрэгтэй. Өдрийн төгсгөлд тухайн нүхэнд хог хаягдал жигд тараасан байх ёстой.
4. Хог хаягдлыг нягтруулах – хог хаягдлыг нягтруулахын тулд бульдозероор дээгүүр нь 4-5 удаа явна. Боломжтой бол нягтруулалт хийхдээ бульдозер хэд хэдэн чиглэлд явж өгнө, гэхдээ хурц үзүүртэй зүйлсийг нягтруулах зорилгоор ийн явж болох ч шавар давхарга дээр явж болохгүй. Нягтруулалт хийх зорилгоор дахиж хэд хэдэн удаа явж болох боловч дахиж явах тусам нягтруулалтын үр дүн нь өмнөх явалтаасаа харьцангуй бага байна.
5. Өдрийн хучилт хийх – тухайн өдрийн сүүлчийн ачилт ирж, хогийг асгаж, тарааж, нягтруулсны дараа нүхийг хөрсөөр (эсвэл байгаль орчинд хоргүй бусад материалаар) хучина. Хог хаягдлын сүүлчийн ачилт нь тухайн өдрийн үйл ажиллагаа дуусахаас 1-2 цагийн өмнө Хог хаягдлын удирдлагын төвийн

Хуудас 4, нийт 9

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ

ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2014-05-24

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E7-PRC-0001-M	Хувилбар: 1.0

ландфилийн цэгт ирсэн байх ёстой. Ингэснээр операторт ажлын талбарыг хөрсөөр хучих, хөрсийг 10см-ийн зузаантай (шаардагдах хамгийн бага хэмжээ) болтол хучиж, ажлын талбарыг 3:1 налуутай болгож, хажуу дах хаагдсан нүхнүүдтэй холбож өгөх хангалттай хугацаа гарна.

### 4.2.2 Хог хаягдал зөөвөрлөх ажлыг зохион байгуулах:

Ландфилийн талбайн хэмжээнээс хамаараад операторууд хог хаягдлыг хүлээж авах, булах ажлыг хийхдээ дараах хоёр хувилбарыг (Хувилбар А, В) ашиглах боломжтой.

- Хувилбар А – Оператор ачаа ирэх болгонд ачааг нүхэнд хийж түрнэ. Ингэснээр хог салхинд хийсэх магадлалыг бууруулах боловч оператор өөр ажил үүрэг гүйцэтгэх боломж олдохгүй. Энэ арга нь байнга салхи шуургатай байдаг цаг агаарын нөхцөлд тохиромжтой; эсвэл
- Хувилбар В – Оператор хэд хэдэн удаагийн ачилт хийж, ажлын талбарт овоолно. Эдгээрийг дараа нь нийлүүлж нэг мөсөн нүх рүү хийнэ. Энэ тохиолдолд оператор ажлын талбар дээр ачааг цуглуулах хооронд өөр ажил үүрэг гүйцэтгэх боломжтой байдаг. Гэхдээ цаг агаарын тохиромжгүй нөхцөлд энэ аргыг ашиглахаас зайлсхийх нь зүйтэй.

### 4.2.3 Тоосжилтыг хянах

- Хог хаягдлын удирдлагын төвийн тоосжилтыг хянахад усны машинууд ашиглана;
- Усны машинууд нь тус төв рүү орох зам, ажлын талбар, ачаа буулгах газар хүртэлх зам болон тоосжилтын хэмжээг бууруулах шаардлагатай бусад газруудыг усална.

### 4.2.4 Шүүрэлтийн менежмент

Шүүрэлтийг цэвэрлэх хоолой нүхнүүдийн баруун талд байрлах бөгөөд үүнийг бөглөрсөн эсэхийг нь тогтмол үзэж шалгаж байх хэрэгтэй. Ерөнхийдөө уг хоолой хугарсан, эвдэрсэн, түүнд хэв гажилт үүссэн эсэхийг 6 сар тутамд шалгах шаардлагатай.

### 4.2.5 Салхинд хийссэн хог

- Хог хаягдал салхинд хийсэхээс хамгаалсан хашааг ажлын талбарын ойролцоо болон ажлын талбараас хийссэн хог хаягдлыг цуглуулах далан дээр барина;
- Хашаа нь хийсч байгаа хог хаягдлыг тогтоохоор хангалттай өндөр байна;
- Хашаан дээр тогтож, цугларсан хогийг тодорхой хугацаанд тогтмол авч цэвэрлэнэ.

## 5 ТОДОРХОЙЛОЛТ

### ХХХ

#### Ерөнхий хог хаягдал

Хувийн Хамгаалах Хэрэгсэл

Оюу Толгойгоос гарсан дахин боловсруулах боломжгүй, өөр тийш нь шилжүүлээгүй ерөнхий хог хаягдал (цаас, картон, хуванцар, метал гэх мэт) Үүнд ландфилийн цэгт хөрсөнд булж устгалд оруулж болохгүй уул уурхайн хог хаягдал хамаарахгүй.

#### Хүнсний хог хаягдал

Ерөнхий хог хаягдлын хэсгээс ирсэн хоолны үлдэгдэл, гал тогооны хог хаягдал

#### Барилга барих/нураах ажлын хаягдал

Хуудас 5, нийт 9

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ

ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2014-05-24

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е7-PRC-0001-М	Хувилбар: 1.0

	Барилга барих, нураах ажлаас гарсан хог хаягдал. Ерөнхийдээ эдгээр хог хаягдал овор ихтэй, том, модон, бетон болон тэдгээртэй төстэй хог хаягдал байдаг.
<b>Зөвшөөрөгдөөгүй хог хаягдал</b>	Устгалд оруулж болохгүй аюултай хог хаягдал, уул уурхайн хог хаягдал.
<b>Нягтруулсан хог хаягдал</b>	Хог хаягдлыг нүхэнд хийсний дараа эзлэх зайг нь багасгахын тулд нягтруулдаг. Хог хаягдлыг буталж, тарааж, бульдозероор дээгүүр нь хэд хэдэн удаа явж нягтруулдаг.
<b>Ажлын талбар</b>	хог хаягдал овоолж, бульдозероор түрж тухайн өдрийн нүхэнд оруулах хэсэг.
<b>Өдрийн нүх</b>	Ландфилийн цэгт нэг өдөрт хүргэгдэж ирсэн хог хаягдлыг тодорхой нэг хэсэгт байрлуулсныг хэлнэ.
<b>Хогийн овоолго/өндөрлөг</b>	Дээрээс нь нэмж хог хийхээс өмнө нягтруулалт хийсэн ихээхэн хэмжээний хог хаягдал.
<b>Өдрийн хучилт</b>	хог хаягдлын хамгийн сүүлчийн хэсгийг хийж, нягтруулсны дараа дээрээс нь хучих хучилт. Хучилт хийснээр үнэр, халдвар тархалт, хогийн тархалтыг багасгаж, ландфилд гал түймэр гарах магадлалыг бууруулна. Хучилтыг хөрсөөр буюу байгаль орчинд хоргүй бусад материалаар хийнэ.
<b>Өдрийн хучилтын бусад материал (ADC)</b>	Байгаль орчинд хоргүй бусад материалаар эсвэл хөрсөөр хучилт хийнэ. Хөрсөөр шүршиж хучих, органик бус гаралтай даавуу, брезинт, бордоо, модны үртэс, үрж жижиглэсэн дугуй, үнс, бусад зүйлс байж болно. Эдгээр материал нь хөрстэй харьцуулахад хог хаягдал хийх зай багтаамжийг хэмнэж өгдөг.
<b>Ландфилийн нүх</b>	Ландфил нь гурван жижиг нүхнээс бүрдэнэ: (1, 2, 3, хойноосоо урагшаа). Нүхнүүдийн хооронд нүх тус бүрээс гарах шүүрэлтийг цуглуулах цөөрөм рүү гаргах хоолой байрлана. Нүхнүүдийн хоорондох зайд хог хаягдал хаявал нүхний шийдлийн ач холбогдол нь багасна.
<b>Ландфилийн доторлогоо</b>	Олон бүрэлдэхүүн хэсгээс бүтэх доторлогооны системийн хамгийн дээд талын өнгөн хэсэг нь хайрга байна. Доторлогооны систем нь (дээрээсээ доошоо дарааллаар): 600 мм-ийн хайрга, нэхээсгүй даавуун эдлэл, 1.5 мм-ийн HDPE, 1000 мм-ийн нягтруулсан шавар, боловсруулсан дэвсгэр үе зэргээс бүрдэнэ. Гэхдээ “доторлогоо” гэдгийг доторлогооны системийн HDPE хэсгийг ойлгоно.
<b>Ландфилийн хий</b>	Органик хог хаягдал задралд орсны улмаас үүсч байгаа хий. Ихэнхи ландфилийн талбайд үнэртдэг үнэр нь энэ хийтэй холбоотой.
<b>HDPE (Өндөр нягтралтай полиэтилен)</b>	Ландфилийн талбайгаас бохирдсон ус шүүрч гүний усны давхарга руу нэвчих нэвчилтийг бууруулах хаалтын давхарга нь зузаан хар нийлэг материал

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е7-PRC-0001-М	Хувилбар: 1.0

**Хийссэн хог хаягдал**

болох HDPE-с бүтдэг. HDPE нь D төрлийн ланфилд тавигддаг ус бага нэвчүүлэх шаардлагыг хангадаг.

Салхинд хийссэн эсвэл ажлын талбараас гарсан хөнгөн хог хаягдал

**Хог хаягдлын шүүрэлт**

Хог хаягдалтай холилдож, бохирдсон ус. Энэ нь хог хаягдлаас гарах шүүрэлт эсвэл хог хаягдал дээр орсон хур танадас байж болно. Шүүрэлт ингэн хайрган доогуур, хог хаягдал, давхаргуудын дундуур урсаж, суулгасан нүхтэй хоолой руу орно. Энэ нь хайрган давхарга доорх доторлогоог нэвтэлж, шүүрсэн шингэнийг ууршуулах цөөрмүүдийн нэг рүү нийлнэ. Шүүрэлтийг ууршуулах цөөрөмийн багтаамж нь ямар ч хэмжээний шингэн цөөрөмд орсон агаарт ууршуулах, шингээх хүчин чадалтай байна.

**6 ЛАВЛАХ МАТЕРИАЛ, ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ**

Монгол улсын хууль тогтоомжид аюултай хог хаягдлын асуудлыг дараах байдлаар зохицуулсан байдаг:

- Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, устгах, хөрсөөр булах тухай харилцааг зохицуулсан Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай Монгол улсын хууль, 2004
- Химийн хорт бодисын импорт, экспорт, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, хяналттай холбоотой харилцааг зохицуулсан Химийн хорт болон аюултай бодисын тухай Монгол улсын хууль, 2004. Уг хуульд хүний эрүүл мэнд, байгаль орчныг химийн хорт болон аюултай бодисын нөлөөнд оруулахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг тусгасан байдаг.
- *Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журмыг тусгаж өгсөн Засгийн газрын 2002 оны 135-р тогтоол.*
- *Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг зайлуулах журмыг тусгасан Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны А-320/305 тоот хамтарсан тушаал;*
- Хог хаягдлыг ланфилийн аргаар хөрсөнд булах, устгах, Хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуй нэгжид тавигдах шаардлагын тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2006 оны 404 тоот тушаал
- Рио Тинтогийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандартууд.

Монгол улсын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэд хэдэн стандартад агаар, хөрс, усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээг зааж өгсөн байдаг. Бизнесийн үйл ажиллагаа явуулсны улмаас бохирдуулагч бодисын хэмжээ нь дээрх заасан хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд *бохирдсон* гэж үздэг.

Дээр дурдсан тогтоол шийдвэрүүд нь уг журмыг боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан холбогдох хууль дүрмүүд болно; энэ журамтай холбоотой байж болох одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль дүрмийн талаар бүрэн дэлгэрэнгүй мэдээллийг Оюу Толгойн Байгаль орчны холбогдолтой хууль дүрмийн бүртгэлээс авч болно.



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E7-PRC-0001-M	Хувилбар: 1.0

### 6.1.1 Бусад дүрэм журам:

- ОУСБ Уул уурхайн БОЭМАА-ны удирдамж, 2007;
- ОУСБ БОЭМАА-ны ерөнхий удирдамж, 2007 (барилгын ердийн хог хаягдал);
- ЕХ Шийдвэр 99/31/ЕС, 1999 (хог хаягдлыг ландфилдэх тухай);
- ЕХ Шийдвэр 2000/76/ЕС 2000 оны 12 сарын 4-ний өдрийн (хог хаягдлыг шатааж устгах тухай);
- ДЭМБ Эмнэлгийн хог хаягдлын аюулгүй менежмент: Бодлогын баримт бичиг, танилцуулах хуудас дугаар 281, (Эрүүл мэндэд хоргүй хог хаягдлын удирдлага);
- Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенци (Монгол улс Базелийн конвенцийг 1997 онд соёрхон баталсан);
- АНУ-ын Байгаль Хамгаалах Агентлагийн батлан гаргасан стандартууд CFR 258 (Хот суурины хатуу хог хаягдлыг зайлуулах ландфилийн шалгуур үзүүлэлтүүд);
- Рио Тинтогийн Гүйцэтгэлийн стандарт: E7 Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын стандарт, E5 аюултай бодис, түүний хор аюулд хяналт тавих стандарт, E9 Газар ашиглалтын хариуцлагын стандарт.

Эдгээр стандартуудад органик бус хог хаягдлын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд төлөвлөх, хөтөлбөр/удирдлагын төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагуудыг тусгаж өгсөн байдаг.

	Нэр	Байршил
<b>Хууль, бусад дүрэм журам</b>	Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, 2012.	Хуулийн бүртгэл
	Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр хадгалах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах тухай Засгийн газрын 2002 оны 135-р тогтоол	
	Эрүүл мэндийн байгууллагын нэг удаагийн хэрэглээний хог хаягдлын тухай Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын 2011 оны А-320/305 тоот хамтарсан тушаал	
	Хог хаягдлыг ланфилийн аргаар хөрсөнд булах, устгах, Хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуй нэгжид тавигдах шаардлагын тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2006 оны 404 тоот тушаал	
<b>Оюу Толгой ЭМААБО Удирдлагын тогтолцоо</b>	Оюу Толгой ЭМААБО УТ Хуулиар тавигдах шаардлагуудын бүртгэл	ОТ Портал
	Онцгой байдлын үеийн удирдлагын төлөвлөгөө	
	Аюултай бодис, бохирдлыг хянах Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө	
	ЭМААБО УТ Эрсдэлийн бүртгэл	



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е7-PRC-0001-М	Хувилбар: 1.0

	<p>Оюу толгойн Байгаль орчин хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналтын хөтөлбөр</p> <p>Оюу Толгой ЭМААБО УТ Аюулыг тодорхойлох, эрсдэлийг удирдах журам (ОТ-03-PRC-0001-Е)</p> <p>Оюу Толгой ЭМААБО УТ Дүрэм, журам зөрчсөнөөс гарсан осол зөрчил, хэрэгжүүлэх арга хэмжээний удирдлагын журам (ОТ-14-PRC-0009-Е)</p>	
	<p>Оюу Толгой ЭМААБО УТ Гүйцэтгэлийг үнэлэх, хяналт тавих журам (ОТ-16-PRC-0001-Е)</p> <p>Оюу Толгой ЭМААБО УТ Өөрчлөлтийн удирдлагын журам ОТ-11-PRC-0001-Е)</p> <p>Шингэн асгарсан үед арга хэмжээ авах журам (ОТ-10-Е5-PRC-0002-Е)</p>	
<b>Мэдээлэл харилцаа/Сургалт</b>	Органик бус хог хаягдлын менежментний талаар мэдлэг олгох сургалт	ОТ Портал

### 7 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	ОТ-10-Е7-PRC-0001-М-Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллах журам
Тодорхойлолт	Байгаль орчны журам
Эх зохиогч	Сюзан Жайлс
Үүсгэсэн огноо	2013.01.20
Баталсан	Марк Ньюби, Байгаль орчны менежер
Баталсан огноо	2013.05.06
Өөрчлөлтийн бүртгэлийн дугаар	##

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
Дундаж	2013.01.20	Баасансүрэнгийн Долгор	2 жил тутам	2015.01.20

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.05.06	Сюзан Жайлс	Марк Ньюби	Баталсан.